



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот


“Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн  
2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн  
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,  
2022 оны зорилтот түвшин батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.16, “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн дүрмийн 4.1, 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг нэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн үндсэн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулж, төсвийн хэмнэлт гаргах чиглэлээр энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүх-Очир/-д, Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.
3. Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 345 тоот, 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 388 тоот тогтоолын 2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүх-Очир/-д, Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаалын 2, 3 дахь заалтын хэрэгжилтийн явц, биелэлтийг улирал бүр нэгтгэж, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн бодлогын газар /Б.Сүх-Очир/-т даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ  
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН



9763000438

Сангийн сайдын 2022 оны 04 дүгээр  
сарын 29 өдрийн 99 тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН  
ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

(мянган төгрөг)

д/д	Үзүүлэлтүүд	2020 оны гүйцэтгэл*	2021 оны		2022 оны Төлөвлөгөө	2021 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		хувь	мөнгөн дүн
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны нийт орлого:</b>	<b>1 124 667</b>	<b>2 738 833</b>	<b>5 520 926</b>	<b>6 033 833</b>	<b>9%</b>	<b>512 907</b>
1,1	Арилжааны шимтгэл	400 061	1 126 551	3 548 107	3 595 374	1%	47 267
1,2	Жилийн хураамж, гүйлчилгээний хөлс	487 952	807 197	1 181 472	2 049 083	73%	867 611
1,3	МИТ ашиглалтын орлого	-	504 023	509 974	-	шинэ	(509 974)
1,4	Бусад	236 654	301 063	281 372	389 376	38%	108 004
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны нийт зардал:</b>	<b>2 101 228</b>	<b>2 719 702</b>	<b>2 168 807</b>	<b>3 269 595</b>	<b>51%</b>	<b>1 100 788</b>
2,1	Үйл ажиллагааны зардал	991 933	1 225 482	990 606	2 036 287	106%	1 045 680
2,2	ҮХ элэгдлийн зардал	266 067	316 269	239 905	497 192	107%	257 287
2,3	МИТ ашиглалтын зардал	843 227	1 177 951	938 295	736 116	-22%	(202 180)
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/</b>	<b>(976 561)</b>	<b>19 131</b>	<b>3 352 119</b>	<b>2 764 239</b>	<b>-18%</b>	<b>(587 881)</b>
4	Орлогын татвар	1 989	-	168 186	276 424	64%	108 238
<b>5</b>	<b>Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>(1 037 795)</b>	<b>19 131</b>	<b>3 183 991</b>	<b>2 487 815</b>	<b>-22%</b>	<b>(696 176)</b>
6	Нийт авлага /цэвэр/	84 131	56 906	97 241	55 267	-43%	(41 974)
7	Нийт өглөг /МИТ төслийн зардал оруулж тооцсоноор/	2 193 451	772 900	926 821	276 424	-70%	(650 397)
8	Ажиллагсдын тоо	53	55	53	56	6%	3
9	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	1,87	0,99	0,39	0,54	38%	0,15
10	Хөрөнгө оруулалт	147 765	176 335	129 930	1 057 830	714%	927 900

Сангийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын  
29 өдрийн 29 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

№	Төсвийн хэмнэлт гаргахтай холбогдуулан авах арга хэмжээ
1	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;
2	Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;
3	Дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх;
4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;
5	Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;
6	Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;
7	Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;
8	Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;
9	Бичиг хэрэг, албан хэрэг хөшөөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах;